Бэлгийн херпес вирус болон Хүний папиллома вирусыг илрүүлж, хэвшинжийг дүйн тодорхойлсон дүн

Б.Жүгдэржав[1,2], Г.Өнөрсайхан[3], С.Цацрал[2], Ч.Эрдэнэчимэг[2], П.Нямдаваа[4], О.Баатархүү[1,4]

[1]АШУҮИС-ийн АУС-ийн Халдварт өвчин судлалын тэнхим
[2]Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв
[3]"Гялс" Анагаах Ухааны Төв
[4]Монголын Анагаах Ухааны Академи

Үндэслэл: Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-ийн Бэлгийн Замаар Дамжих Халдвар (БЗДХ)-ын кабинетаар үйлчлүүлэгчдэд вируст халдвар илрүүлэх шинжилгээний хүртээмж хангалтгүй, тархалт тодорхойгүй байдаг тул нүклейн хүчилд тулгуурласан микроэррэйн аргаар бэлгийн замын сорьцонд энгийн херпесийн вирус (ХВ) болон хүний папиллома вирус (ХПВ) илрүүлж дүйн тодорхойлох шинжилгээ хийлээ.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгааг ХӨСҮТ-ийн БЗДХ-ын тандалт судалгааны албаны амбулаториор үйлчлүүлсэн эрэгтэй, эмэгтэй үйлчлүүлэгчийн шээсний сүв, умайн хүзүү, үтрээний арчдас зэргээс авч, нийт 1196 шинжлэгдэхүүнийг нүклейн хүчил нэвчүүлэн эрлийзжүүлэх микроэррэйн аргаар GeneFlow-STD Array Test, GeneFlow-HPV Array Test, DiagCor, HK оношлуурын цомгуудаар хийж үр дүнг тооцлоо.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 0.8% (9)-д HSV 1\2-ийн халдвар, 3.3% (39)-д нь HPV 6\11 илэрсэн. Эмэгтэйчүүдэд илэрсэн ХПВ-ийн 33 хэв шинжийг дүйн тодорхойлоход: 33 хэв шинжийн аль нэг нь 30.5% (178)-д дан болон хавсарсан байдлаар илэрсэн. ХПВ-ийн халдварын тархалтыг насны ангиллаар авч үзвэл 19-24 насны залуу эмэгтэйчүүдийн дунд өндөр буюу 50% (53/106)-тай байна. Тэр дундаа бэлгийн замын үрэвсэлт өвчний (БЗҮӨ) шинж тэмдэггүй эмэгтэйчүүдийн 19-24 насанд ХПВ-ийн халдвар хамгийн өндөр буюу 75% (12/16)-тай байна ($p<0.001$). Мөн БЗҮӨ-ий шинж тэмдэгтэй эмэгтэйчүүдийн 30.9% (130/420)-д, шинж тэмдэггүй эмэгтэйчүүдийн 29.6% (48/162)-д ХПВ илэрсэн. Илэрсэн вирусийн хэвшинжийг дүйн тодорхойлоход 16-р хэв шинж 14.6% (26)-д байгаа ба 31-р хэв шинж 11.2% (20)-д, 52-р хэв шинж 10.1% (18)-д, 81-р хэв шинж 8.9% (16)-д тус тус илэрсэн нь ХПВ-ийн халвадрын өндөр эрсдэлтэй хэв шинжүүд давамгайлж байгааг харуулж байгаа юм.

Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан БЗҮӨ-ний шинж тэмдэгтэй болон шинж тэмдэггүй эмэгтэйчүүдийн хувьд ХПВ-ийн халдварын тархалтанд ялгаа ажиглагдахгүй байгаа нь харьцангуй эрүүл эмэгтэйчүүдийн дунд ХПВ-ийн халдвар өндөр хувьтай байгааг харуулж байна.

Түлхүүр үгс: Херпесийн вирус, Хүний папиллома вирус, Нүклейн хүчилд тулгуурласан арга

ЭШЛЭЛ

The results of detecting and genotyping for Herpes simplex virus and Human papillomavirus

Jugderjav B[1,2], Unursaikhan G[3], Tsatsral S[2], Erdenechimeg Ch[2], Nymadawa P[4], Baatarkhuu O[1,4]

[1]MNUMS
[2]National Center for Communicable Diseases, Ulaanbaatar, Mongolia;
[3]"Gyals" Medical Center
[4]Mongolian Academy of Medical Sciences

Introduction: Diagnostic methods for STIs currently used in Mongolia fail to detect Viral STIs. Therefore, we used a nucleic acid detection method to identify the Herpes Simplex Virus (HSV) and human papillomavirus (HPV)'s an infection and included the results in this report.
Materials and methods: This study population was visited STI ambulatory of the National Center for Communicable Diseases (NCCD). A total of 1196 cervical and urethra swab samples were collected, using GenoFlow-STD Array and GeneFlow-HPV Array, DiagCor, HK test kits based on Flow-throw hybridization method.
Results: HSV 1\2 detected in 0.8% (9) of total sample population. While HPV 6\11 genotypes were detected in 3.3% (39) of total sample population. Female samples were tested for HPV's 33 genotypes and HPV was detected in 30.5% (178) and infections were either single or combination of multiple genotypes. Alarmingly, the most commonly detected genotypes were HPV 16 [14.6% (26)], 31[11.2% (20)], 52 [10.1% (18)], and HPV 81[8.9% (16)] which are the high risk genotypes of HPV.
Conclusion: HPV infection is high among the general population because HPV was most often detected in asymptomatic patients compared to symptomatic patients.

Keywords: Human papillomavirus, Herpes Simplex Virus, Nucleic Acid Hybridization Method